



Verifone®

Верифоне IntelliNAS

Гүйлгээний бүтцийг илүү хурдан бөгөөд ухаалаг болгосон


Төлбөрийн бүтцээ илүү хүчирхэг хурдан болгоорой.

Таны гүйлгээний бүтэц машины хөдөлгүүр шиг ажиллаж байна гэж төсөөлөөд үз дээ. Хамгийн дээд хүчин чадлаараа ажиллаж байна уу? эсвэл төлбөрийн хурд, хүчин чадал нь нэмэлт дэмжлэгийг хэрэглэж чадаж байна уу? Верифоне IntelliNAC бол үнэтэй сайжруулалт хийх шаардлагагүйгээр таны одоо хэрэглэж буй бүтцийг үр ашигтай болгохоор зохион бүтээсэн техник хангамж болон програм хангамжийн систем юм. Энэхүү систем нь өндөр нягтаршил, олон талын үйлдэл, ПОС-ын сүлжээнд хандах хяналт зэрэг урьд өмнө байгаагүй гүйцэтгэлийг олгохын зэрэгцээ гүйлгээний олон мянган замыг хурдан, нууцлалтай, найдвартай болгодог юм.

Гүйлгээг шилжүүлэн зохицуулж, гүйлгээний тоог дээд хэмжээнд нь хүргээрэй.

Гүйлгээ шилжүүлэх нь маш их нууцлалтай бөгөөд ялангуяа оргил үеэр олон газарт хүргэх янз бүрийн зам ашиглах боломжийг шаардан төвөгтэй байж болох юм. Ингэснээр төлбөр боловсруулагч нь ихэнхдээ тусгайлан тухайн бизнесийн гүйлгээнд хяналт тавих дүрэм гаргах хэрэгтэй болдог.

IntelliNAC нь энэхүү хэрэгцээ шаардлагыг олж харсан бөгөөд энэхүү системээр гүйлгээ хэрхэн, хаана хийгдсэнийг хянах тусгай бизнесийн логик боломжийг процессорт олгон бүхэлд нь тохиргоо хийх боломжтой юм. Үүний зэрэгцээ програм хангамжийн онцлог нь хэрэглэгчдэд цаашид гүйлгээ удирдах нэгдсэн тайлан, оношилгооны үйлдлээр дамжуулан хувийн тохиргоо хийх, мэдээлэлд анализ хийх зэрэг бололцоог өгдөг юм. IntelliNAC-аар одоо хэрэглэж буй бүтэц дээрээ илүү олон гүйлгээг хүлээн авч, гүйлгээ шилжүүлэх хэлбэрээ дээд хэмжээнд нь нэмэгдүүлээрэй.



Батлагдсан сайн гүйцэтгэл, найдвартай байдал болон нууцлал

Одоогоор 120 гаруй оронд байршуулан дэлхийн картын өнөөгийн дебит, кредит гүйлгээний 60%-аас дээш дэмжиж буй Верифоне NAC сүлжээний багцын шийдлийг хамгийн сайн хурд нууцлалаар хангахын тулд дээд зэргийн стандартуудыг суулгасан байдаг. Бүрэн удирдаж болдог сүлжээний боломж нь бат бөх дизайн, алдаанд тэсвэртэй програм хангамж, нэмэлт орон зайн боломжтой учраас туйлын найдвартай байдал, ажиллагааны хамгийн урт хугацааг олгон бүх ПОС төхөөрөмжийг дэмждэг юм.

Ухаалаг хяналт

IntelliNAC-ийн бүрэн тохируулж болох сүлжээний менежментийн хэрэглээ нь бизнесийн логикийг дэмжин ажилладаг бөгөөд таны одоогийн гүйлгээ боловсруулах системийн хурд, хүчин чадлыг нэмэгдүүлдэг юм. 100% мэдээллийн агуулгаа ойлгодог IntelliNAC нь гүйлгээ бүр дэх олон төрлийн мэдээллийг шалгасны дараа хэрхэн боловсруулахаа зохицуулахын тулд тухайн харилцагчид тохирсон дүрмийг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, IntelliNAC нь хурд, нууцлал, найдвартай байдлыг сайжруулахын зэрэгцээ хост платформын ачааллыг арилгаж, гүйлгээгээ хаана хэрхэн боловсруулах хэрэгтэйг тодорхойлохын тулд доторх мэдээллээ богино хугацаанд хурдан шалгадаг юм.



Сүлжээний бүрэн харагдах байдал

Нэгдсэн сүлжээний менежмент тайлангийн систем IntelliView нь IntelliNAC төхөөрөмжид багтсан програм хангамжийн нэг хэсэг юм. Энэхүү систем нь төлбөрийн бүтцээ хамгийн сайн гүйцэтгэлээр ажиллаж буйг баттай болгохын тулд гүйлгээний системээ хянах боломжийг төлбөр боловсруулагчдад олгодог. IntelliView-ээр:

- Гүйлгээ боловсруулалтыг хялбархан тохируулахын тулд IntelliNAC төхөөрөмжүүдээ удирдаарай.
- Тайлагнах, оношлох үйлдлийг нэгтгэх гол үүргийг хэрэгжүүлдэг.
- Зөвхөн таны бизнест л хамааралтай хийхэд төвөгтэй тохиргоог хялбарчилна.

Гүйлгээний хэмжээний тодорхой байдал

IntelliNAC шийдэлд LogARithm-ыг програм хангамжийн нэмэлт хэсгээр оруулснаар өдөр бүр 50 сая хүртэл гүйлгээг хүлээн авч хадгалдаг. Тайлан гаргах болон чиг хандлага, хяналтын ажиллагаа, системийн бодит асуудлыг оношлох буюу хувийн гүйлгээг нарийвчлан харахын тулд гүнзгийрүүлсэн статистик анализ хийхдээ бодит хугацааны өгөгдлийг ашиглаарай. Түүнчлэн доорх үйлдлийг хийж болно. ҮҮНД:

- Гүйлгээ шилжүүлгийн саатлаас сэргийлэх хязгаарлалтын дохио тавих
- Гүйлгээний алдааг танд мэдэгдэх дохио тавих
- Өгөгдлийг түгээмэл хэрэглэдэг цогц програмууд болох Microsoft Excel, Access-д цаашид анализ хийхэд зориулж гаргах

ЯАГААД ВЕРИФОНЕ ГЭЖ?

Өөр байх нь хялбар боловч илүү сайн байх нь хэцүү.

~5.4Тэрбум 30 Сая 30 Жил 60%

Верифоний төхөөрөмжүүд нь дэлхий даяар жил бүр дунджаар 5.4 тэрбум гүйлгээ хийдэг. Энэхүү зах зээлийн хэмжээгээр, бид үргэлж өөрсдийгөө шинэлэг байдал руу түлхэн оруулж шинэчлэлээ түгээж байна.

Бид 30 сая Верифоне төхөөрөмжөө дэлхий даяар байршуулан, бүх хэмжээний бизнес эрхлэгчдэд хэрэглэгчдийг нь ПОС-той харьцуулах боломжийг олгож байна.

Верифоне IntelliNAC нь 30 гаруй жилийн турш батлагдсан сайн гүйцэтгэл болон хамгийн чухал стандартыг суулган ажиллаж байна.

Верифоне NAC багцын бүтээгдэхүүнийг 120 гаруй оронд байршуулан ашиглаж дэлхийн өнөөгийн дебит, кредит картын гүйлгээний 60%-с дээш дэмжиж байна.